



## **АУДИТЫН КОД: САГ-2018/07/СТА-ТЕЗ**

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дараах хаягаар авна уу.

Цахим хуудас: [www.audit.mn](http://www.audit.mn)

Санхүүгийн аудитын газрын захирал бөгөөд тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг

Утас: 261663 Цахим хаяг: [naranchimegts@audit.gov.mn](mailto:naranchimegts@audit.gov.mn)

Санхүүгийн аудитын газрын захирал бөгөөд тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг

Утас: 261663 Цахим хаяг: [naranchimegts@audit.gov.mn](mailto:naranchimegts@audit.gov.mn)

Аудитын менежер Я.Самбууням

Утас: 261885 Цахим хаяг: [sambuunyamy@audit.gov.mn](mailto:sambuunyamy@audit.gov.mn)

Ахлах аудитор Р.Цолмон

Утас: 260512 Цахим хаяг: [tsolmonr@audit.gov.mn](mailto:tsolmonr@audit.gov.mn)

Аудитор Б.Баярмаа

Утас: 261740 Цахим хаяг: [bayarmaab@audit.gov.mn](mailto:bayarmaab@audit.gov.mn)

Улаанбаатар хот



## Агуулга

1	ТАЙЛАНГИЙН ХУРААНГУЙ .....	2
2	АУДИТЫН ГЭРЧИЛГЭЭ.....	4
3	АУДИТЫН ТАЙЛАН .....	6
3.1	Оршил .....	6
3.2	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага .....	6
3.3	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин .....	7
3.4	Аудитын шалгуур үзүүлэлт, арга зүй, хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	7
3.5	Дотоод хяналт .....	8
3.6	Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга.....	8
3.7	Шилэн дансны мэдээлэл .....	10
3.8	Төлөвлөлтийн шатанд тооцсон эрсдэл, түүний үр дагавар.....	10
3.9	Аудитаар илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал, гаргасан шийдэл .....	11
3.9.1	Харьяа байгууллагын санхүүгийн тайланд аудит хийхэд илэрсэн алдаа, зөрчилтэй асуудал .....	11
3.9.2	Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар илэрсэн алдаа, зөрчилтэй асуудал.....	11
3.10	Анхаарал татахуйц бусад чухал асуудал .....	11
3.11	Завсрын аудитаар авч үзэх асуудлууд .....	11
3.12	Аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл .....	11
3.13	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	12
3.14	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар .....	12
3.15	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл .....	12
3.16	Үр өгөөжийн тооцоолол .....	12
4	МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ.....	13
4.1	Санал тоолох машин, програм хангамжийн ашиглалтын талаар .....	14
5	АУДИТ ХИЙГДСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ.....	15
5.1	Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан.....	15
5.2	Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....	16
5.3	Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	17
5.4	Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	18
5.5	Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	19



**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ АУДИТОР**

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг  
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр  
Утас:26-04-37, Факс:62-26-32-30

2018.04.25 № 1037  
танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

СОНГУУЛИЙН ЕРӨНХИЙ ХОРООНЫ  
ДАРГА Ч.СОДНОМЦЭРЭН ТАНАА

**Аудитын гэрчилгээ**

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.5-д заасны дагуу Сонгуулийн ерөнхий хорооны даргын төсвийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

**Зөрчилгүй санал дүгнэлт**

Сонгуулийн ерөнхий хорооны даргын төсвийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

**Санал дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Сонгуулийн ерөнхий хорооны даргын төсвийн 2017 оны жилийн эцсийн төсвийн нэгтгэсэн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагын мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

\\10.10.10.20\Bichig\_Kheregi\Yawsan\_Bichig\2018\0425SAG27.Docx

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА  
**ЗӨРЧИЛГҮЙ  
САНАЛ ДҮГНЭЛТ**

### Үүрэг, хариуцлага

Төсвийн ерөнхийлөн захирагч нь Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.3-т заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ АУДИТОР



Д.ХҮРЭЛБААТАР

\\10.10.10.20\Bichig\_Khereg\Yawsan\_Bichig\2018\0425SAG27.Docx

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА  
ЗӨРЧИЛГҮЙ  
САНАЛ ДҮГНЭЛТ

### 3 АУДИТЫН ТАЙЛАН

#### 3.1 Оршил

Сонгуулийн ерөнхий хорооны даргын төсвийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайланг Сонгуулийн ерөнхий хорооны дарга Ч.Содномцэрэн танд танилцуулж байна.

Энэхүү тайланд тус байгууллагын санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, залруулаагүй материаллаг биш алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт, үр дүнгийн талаарх тайлбар тодруулга, аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Менежментийн захидалд тус байгууллагын үндсэн чиг үүргээ хэвийн зохион байгуулж, хэрэгжүүлэхэд шаардлагатай сонгуулийн санал хураах машины ашиглалттай холбоотой төсвийн хөрөнгийг үр ашигтай, хэмнэлттэй төлөвлөхөд анхаарч ажиллах талаар зөвлөмжийг тусгасан болно.

Аудитын явцад Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан Санхүүгийн аудитын журам, гарын авлагад дурдсан аудитын төлөвлөлт, гүйцэтгэл, тайлагналын үе шатны ажлыг гүйцэтгэж, баримтжуулсан бөгөөд аудитад баримталсан стандарт, зарчим, үйл явцын талаарх мэдээллийг аудитын санал дүгнэлтэд тодорхойлсон болно.

#### 3.2 Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.5-д заасны дагуу Сонгуулийн ерөнхий хорооны даргын төсвийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийлээ.


Аудитыг Төсвийн тухай, Төрийн аудитын тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандарт, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Сонгуулийн ерөнхий хорооны даргын төсвийн 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт /цаашид УСНББОУС гэх/, түүнд нийцүүлэн гаргасан төрийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн ерөнхийлөн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2018 оны 4 дүгээр сарын 6-наас 2018 оны 4 дүгээр сарын 11-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2018 оны 4 дүгээр сарын 25-нд эцэслэн баталгаажуулж, Төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Үндэсний аудитын газрын Санхүүгийн аудитын газрын ахлах аудитор Р.Цолмон, аудитор Б.Баярмаа нар хариуцаж хэрэгжүүлэв.





Сонгуулийн ерөнхий хорооны дарга 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Үндэсний аудитын газарт 2018 оны 2 дугаар сарын 28-ны өдрийн 29 дүгээр албан бичгээр буюу Төсвийн тухай хуулиар тогтоосон хугацаанд ирүүлсэн байна.

### 3.3 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Сонгуулийн ерөнхий хороо нь Монгол Улсын Их Хурлын болон Ерөнхийлөгчийн сонгууль, Ард нийтийн санал асуулгыг бэлтгэн явуулах ажлыг төлөвлөж, зохион байгуулах, сонгуулийн хороодыг нэгдсэн удирдлагаар хангах, аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийг зохион байгуулж явуулах ажлыг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах чиг үүргийг эрхлэн гүйцэтгэж байна.

Сонгуулийн ерөнхий хорооны дарга дээрх чиг үүргийг хэрэгжүүлэх зорилгоор тайлант хугацаанд явуулсан үйл ажиллагаа, түүний үр дүнгийн талаар хураангуйлан тэмдэглэв.

Сонгуулийн ерөнхий хороо тайлант хугацаанд төлөвлөсөн ажлаа дараах чиглэлээр дэлгэрэнгүй тайлагнасан бөгөөд Монгол Улсын 2017 оны төсвийн тухай хуулийн 1 дүгээр хавсралтаар Сонгуулийн ерөнхий хорооны даргын 2017 онд хэрэгжүүлэх хөтөлбөр, түүний хүрэх үр дүнгийн зорилтот түвшинг 8 үзүүлэлтээр баталгаажуулсныг дараах гүйцэтгэлтэй хэрэгжүүлсэн байна. Үүнд:

- ✓ Сонгуулийн хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбоотой боловсруулах журам, заавар, маягт 40 байхаар төлөвлөж, 46 журам, заавар, маягт боловсруулж баталсан;
- ✓ Сонгуулийн хууль тогтоомжийг сурталчлах сургалт, семинарын 60 удаа зохион байгуулахаар төлөвлөж, 61 удаагийн сургалт зохион байгуулсан;
- ✓ Сонгогчдын боловсролыг дээшлүүлэх, өмнөх оны суурь үзүүлэлтээс 5.0 хувиар өсөхөөр төлөвлөж, биелэлт 9.5 хувьтай;
- ✓ Сонгуулийн хорооны үйл ажиллагаанд 47 удаа хяналт, шалгалт хийхээр төлөвлөж, 51 удаа гүйцэтгэсэн;
- ✓ Сонгуульд оролцсон нам, эвсэл, бие даан нэр дэвшигчийн зардлын тайланг 3 удаа хянахаар төлөвлөж, биелэлт 100 хувь;
- ✓ Сонгуулийн автоматжуулсан системийг бүрэн ашиглах, хэвийн үйл ажиллагаа, санал хураах тоног төхөөрөмжийн бэлэн байдлыг хангах тоо 5000 байхаар төлөвлөж,
- ✓ Программ хангамжийн аюулгүй ажиллагааг бүрэн хамгаалсан байх үүргээ 100 хувь;
- ✓ Мэдээллийн бааз 21-ийг үүсгэхээр төлөвлөж, биелэлт 100 хувьтай тус тус гүйцэтгэсэн байна.

Сонгуулийн ерөнхий хорооны үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд судалж, баримтжуулсан.

### 3.4 Аудитын шалгуур үзүүлэлт, арга зүй, хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудит хийхэд Аудитын олон улсын стандарт, Аудитын дээд байгууллагуудын олон улсын стандарт 1000 – 1810 буюу Санхүүгийн аудитын удирдамж, Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

Аудитаар Сонгуулийн ерөнхий хорооны даргын төсвийн 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд санал дүгнэлт өгөх зорилгоор тэдний бэлтгэсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд аудитын чиглэл тус бүрийн уламжлалт болон хяналтын эрсдэлийг төлөвлөсөн хэмжээнд үнэлснээс гадна Сонгуулийн ерөнхий хорооны зүгээс тавьж буй дотоод хяналтыг үнэлж баримтжууллаа.

Дотоод хяналтын талаарх гол асуудал, дүгнэлтийг энэ



Санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, аудитын 4 чиглэлээр түүвэрчилсэн байдлаар аудитын 21 хяналтын сорил болон нарийвчилсан горимыг гүйцэтгэж баримтжууллаа. /ТАБ-СТА-В-3/

Эдгээр горим сорилыг хэрэгжүүлэх явцад илэрсэн алдаа, зөрчилтэй зарим гол асуудлыг энэ тайлангийн 3.9 дэх заалтад хураангуйлан тэмдэглэв.

Сонгуулийн ерөнхий хорооны нягтлан бодох бүртгэлийн бодлого, системтэй танилцахад 2013 онд Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулж баталсан бөгөөд өмнөх оны аудитын зөвлөмжийн дагуу 2017 онд нэмэлт өөрчлөлт оруулан үйл ажиллагаандаа хэрэгжүүлж байна.

Сонгуулийн ерөнхий хорооны даргын төсвийн санхүүгийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн төвөгтэй байдлыг үнэлэхэд эрсдэл бага буюу мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзсэн тул аудитыг томилогдсон баг гүйцэтгэлээ.

Сонгуулийн ерөнхий хорооны даргын төсвийн санхүүгийн нэгтгэсэн тайланг бэлтгэхэд төсвийн байгууллагын санхүүгийн тайланг нэгтгэдэг “Э-тайлан” програм хангамжийг ашиглажээ.

### 3.5 Дотоод хяналт

Бид санхүүгийн нэгтгэсэн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Сонгуулийн ерөнхий хорооны дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт хэвийн гэж үзлээ.


Сонгуулийн ерөнхий хороо нь бүтэц орон тоо, үйл ажиллагааны цар хүрээнээс шалтгаалж Төсвийн тухай хуулийн 69 дүгээр зүйлийн 69.1-т заасны дагуу байгууллагын үйл ажиллагаанд хяналт тавих дотоод хяналтын нэгжийг ажиллуулаагүй боловч байгууллагын өдөр тутмын ажилд ажлын албаны дарга, хорооны дарга нар хяналт тавин ажиллаж байна.

Мөн өмнөх аудитаар дотоод аудитын нэгж ажиллуулах талаар зөвлөмж өгсөн боловч Монгол Улсын 2018-2020 оны төсвийн төсөл бэлтгэх тухай Сангийн сайдын 2017 оны 7 дугаар сарын 04-ний өдрийн 4-1/4115 дугаар албан бичгээр ирүүлсэн удирдамжийн 2 дугаар бүлгийн 6 дахь хэсэгт “Бүтцийн өөрчлөлт, бусад шийдвэрээр орон тоо, урсгал зардал нэмэгдүүлэхгүй байх” шаардлагуудыг баримтлан ажиллахыг даалгасан байна. Мөн тус хорооны удирдлагууд Сангийн сайдтай биечлэн уулзаж орон тоог зайлшгүй нэмэгдүүлэх шаардлагатай байгаа тухай танилцуулсан боловч Олон улсын валютын сантай хийсэн гэрээ, эдийн засгийн нөхцөл байдлаас шалтгаалан орон тоог нэмэгдүүлэх боломжгүй гэсэн хариу өгсөн байна.

### 3.6 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Монгол Улсын 2017 оны төсвийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулиар Сонгуулийн ерөнхий хорооны даргын төсвийн багцад 2017 онд хэрэгжүүлэх 8 хөтөлбөр, түүний хүрэх үр дүнгийн зорилтот түвшинг баталгаажуулжээ.

Дээрх хуулиар Сонгуулийн ерөнхий хорооны төсвийн ерөнхийлөн захирагчид батлагдсан хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд зориулж нийт зардалд 15,761.0 сая төгрөг байхаар баталж, үүнээс Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн зардалд төсвийн 14,954.4 сая төгрөгийг төлөвлөж, 806.9 сая төгрөгийг урсгал зардалд зарцуулахаар баталсан бөгөөд хөрөнгийн зардал төсөвлөгдөөгүй байна.



Төсөвт зардлын гүйцэтгэл нийт дүнгээрээ 97.4 хувь буюу 416.4 сая төгрөгөөр хэмнэлттэй байна. Урсгал зардалд 739.1 сая төгрөг зарцуулж, батлагдсан төсвийг 67.8 сая төгрөгөөр, сонгуулийн зардалд 14,605.5 сая төгрөг зарцуулж, батлагдсан төсвийг 348.6 сая төгрөгөөр, хэмнэжээ.

Хүснэгт №1 Батлагдсан төсвийн төлөвлөгөө, гүйцэтгэлтэй харьцуулсан.

/сая.төг/

д/д	Зардал	Батлагдсан төсөв	Гүйцэтгэл	Хэмнэлт
1	Сонгуулийн зардал	14,954.1	14,605.5	348.6
2	Үндсэн ү/а-ны урсгал зардал	806.9	739.1	67.8
	Дүн	15,761.0	15,344.6	416.4

Эх сурвалж: Төсвийн гүйцэтгэлийн тайлан

Мөн тайлант онд Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 182 дугаар тогтоолоор Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2017 оны ээлжит сонгуулийн 2 дахь санал хураалтад Засгийн газрын нөөц хөрөнгөөс 7,200.0 сая төгрөгийн нэмэлт санхүүжилт өгч, үүнээс 7,181.1 сая төгрөгийг зарцуулан 18.9 сая төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Сонгуулийн ерөнхий хорооны даргын төсвийн 2017 оны Төсвийн гүйцэтгэлийн тайлангаас үзэхэд төсөвт зардлыг ерөнхий ангиллаар хэтрүүлээгүй, төсвийг батлагдсан төсвийн хүрээнд зарцуулж, Төсвийн тухай хуулийг мөрдөж ажилласан байна.

ҮАГ-ын Нийцлийн аудитын газраас Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн зардлын гүйцэтгэлд аудит хийж дүгнэлт, зөвлөмж өгсөн байна. Аудитаар аймаг, нийслэлийн төрийн аудитын байгууллагаас 28.4 сая төгрөгийн зөрчилд 9 төлбөрийн акт тогтоож, 157.4 сая төгрөгийн зөрчилд 6 албан шаардлага хүргүүлжээ.

Төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5-д заасны дагуу гаргаж ирүүлсэн байна.

Сонгуулийн ерөнхий хорооны даргын төсвийн үндсэн үйл ажиллагааны урсгал зардалд 806.9 сая төгрөг төлөвлөгдсөнөөс гүйцэтгэлээр 91.6 хувь буюу 739.1 сая төгрөг зарцуулж, 67.8 сая төгрөг хэмнэсэн байна.


Хүснэгт № 2 Батлагдсан төсвийн төлөвлөгөө, гүйцэтгэлтэй харьцуулсан

/сая.төг/

д/д	Зардлын ангилал	Батлагдсан төсөв	Гүйцэтгэл	Хэмнэлт
1	Цалин хөлс	440.3	392.9	47.4
2	НДШ	48.4	44.2	4.2
3	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	8.6	5.8	2.9
4	Хангамжийн материал	49.3	47.1	2.2
5	Томилолт, зочны зардал	6.7	4.0	2.7
6	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээ	195.4	194.6	0.8
7	Бараа үйлчилгээний бусад	16.8	12.9	3.9
8	Урсгал шилжүүлэг	41.3	37.6	3.7
	Дүн	806.9	739.1	67.8

Эх сурвалж: Төсвийн гүйцэтгэлийн тайлан

Батлагдсан төсөв, гүйцэтгэлийн талаарх мэдээллийг энэ тайлангийн 5.5-д дэлгэрэнгүй харуулав.





### 3.7 Шилэн дансны мэдээлэл

Сонгуулийн ерөнхий хорооны төсвийн ерөнхийлөн захирагчийн хувьд Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг “shilendans.gov.mn” цахим хуудсаар “Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох тухай журам”-ын дагуу хуульд заасан хугацаанд жил, улирал, сар, тухай бүр ил тод мэдээлж ажилласан байна. Тухайлбал:

- ✓ “Төсөв” цэсний Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх тоон болон чанарын үзүүлэлт, биелэлт, дараа жилийн төсвийн төсөл, санхүүгийн тайлан зэрэг мэдээллийг тус тус 1 удаа;
- ✓ “Төсөв” цэсний Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн хөтөлбөр, зориулалтын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт, хэмнэлтийн шалтгаан тайлбарын хамт, тухайн жилийн төсөвт орсон нэмэлт өөрчлөлтийн мэдээг тус тус 12 удаа;
- ✓ “Хөрөнгө оруулалт, тендер худалдан авалт” цэсэнд Монгол Улсын 2017 оны төсвийн тухай хуулиар хөрөнгө оруулалтын төсөв батлагдаагүй тул хамааралтай мэдээлэл байхгүй;
- ✓ “Бусад” цэсний Бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл...төсөв, өмч, хөрөнгө мөнгө зарцуулах, өр авлага үүсгэсэн аливаа шийдвэр хэсэгт хорооны даргын хөрөнгөтэй холбоотой захирамжийг сар бүр мэдээлж ажилласан байна.

Мөн тус хуулийн хэрэгжилтийн хүрээнд Сонгуулийн ерөнхий хорооны даргын 2014 оны 40 дүгээр захирамжаар Сонгуулийн ерөнхий хорооны Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангах, түүнд дотоод хяналт тавих ажлын хэсэг байгуулж, ажлын ерөнхий төлөвлөгөө баталсан байна. Үүний дагуу Сонгуулийн ерөнхий хорооны төсвийн ерөнхийлөн захирагчийн болон ажлын алба, түүний дэргэдэх Мэдээлэл технологийн төвийн 3 шилэн дансны цахим хуудас ажиллуулсан байна.

2017 онд шилэн дансны цахим хуудаст мэдээлэл байршуулсан байдлыг харуулбал:

- ✓ Сонгуулийн ерөнхий хорооны даргын шилэн дансны цахим хуудаст нийт 142 мэдээлэл,
- ✓ Сонгуулийн ерөнхий хорооны ажлын албаны шилэн дансны цахим хуудаст нийт 149 мэдээлэл,
- ✓ Мэдээлэл технологийн төвийн шилэн дансны цахим хуудаст нийт 149 мэдээллийг тус тус байршуулан ажилласан байна.

Дээрх мэдээллийг нийтэд ил тод мэдээлсэн талаарх нотлох баримтыг ажлын баримт материалд хадгалав.


Үндэсний аудитын газраас Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд 2017 оны байдлаар нийцлийн аудит хийхэд Сонгуулийн ерөнхий хороотой холбоотой зөрчил дутагдал илрээгүй байна.

### 3.8 Төлөвлөлтийн шатанд тооцсон эрсдэл, түүний үр дагавар

Аудитын төлөвлөгөөний дагуу аудитын 4 чиглэлд эрсдэл тогтоож, батламж мэдэгдлүүдийн хүрээнд данс бүрээр нийт 21 нарийвчилсан горим, сорил гүйцэтгэв.

Хэрэгжүүлсэн горим сорилын үр дүнг гүйцэтгэлийн үе шатны “Төлөвлөсөн горим, сорилуудыг хэрэгжүүлж, үр дүнг аудитын чиглэл тус бүрээр баримтжуулах” гэсэн үе шатны ажилд хамааруулан ТАБ-СТА-В-3 маягтаар данс тус бүрээр баримтжуулсан болно.

Дээрх горим сорилыг хэрэгжүүлэх явцад илэрсэн зарим зөрчилтэй асуудлыг энэ тайлангийн 2.9-д хураангуйлан тэмдэглэв.



### **3.9 Аудитаар илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал, гаргасан шийдэл**

#### **3.9.1 Харьяа байгууллагын санхүүгийн тайланд аудит хийхэд илэрсэн алдаа, зөрчилтэй асуудал**

Сонгуулийн ерөнхий хорооны дэргэдэх Мэдээлэл технологийн газрын 2017 оны санхүүгийн тайланг түүвэрт хамруулан шалгасан бөгөөд зөрчилтэй асуудал илрээгүй болно.

#### **3.9.2 Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар илэрсэн алдаа, зөрчилтэй асуудал**

Сонгуулийн ерөнхий хорооны даргын төсвийн 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланд шууд нэгтгэгддэг Мэдээлэл технологийн төвийг түүвэрт хамруулан шалгасан бөгөөд аудитын явцад байгууллагын үйл ажиллагааг цаашид хэвийн явуулах нөхцөл бололцоогоор хангахын тулд анхаарвал зохих дараах асуудалд зөвлөмж хүргүүлэхээр шийдвэрлэв.

##### **3.9.2.1 Санал тоолох машин, програм хангамжийн ашиглалтын талаар**

Үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй 12,951.3 сая төгрөгийн анхны өртөг бүхий сонгуулийн санал тоолох машин болон програм хангамжийн ашиглах хугацаа 2017 онд дуусч, элэгдлийн зардлаараа өртгөө бүрэн нөхөж дууссан байна. Гэвч уг хөрөнгийг дахин ашиглах, актлаж устгах, худалдах эсэх талаар өмч хамгаалах комиссын дүгнэлт гаргаагүй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйл “эзэмшилдээ байгаа илүүдэл буюу ашиглах хугацаа дууссан, шаардлага хангахгүй болсон эд хөрөнгийг худалдах, шилжүүлэх, устгах” хэсгийн 31.3.1-д “худалдах, шилжүүлэх, устгах эд хөрөнгийн талаар өмч хамгаалах Байнгын зөвлөл дүгнэлт гаргасан байх”, 31.3.2-т “илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нь нөхсөн, ... засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн үнийг төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай зөвшилцөн тогтоох” заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Дээрх хөрөнгийн цаашид ашиглагдах боломжийг харгалзан үзэж хөрөнгийг дахин үнэлэх, шаардлагатай хөрөнгийн асуудлыг холбогдох байгууллагаар шийдвэрлүүлэх талаар менежментийн захидлаар зөвлөмж өгөхөөр шийдвэрлэв.

### **3.10 Анхаарал татахуйц бусад чухал асуудал**


Сонгуулийн ерөнхий хорооны даргын төсвийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар анхаарал татахуйц асуудал гараагүй байна.

#### **3.11 Завсрын аудитаар авч үзэх асуудлууд**

Сонгуулийн ерөнхий хорооны даргын төсвийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитын явцад гүйцээж мөшгин шалгаж амжаагүй эрсдэлтэй асуудал гараагүй тул завсрын аудитаар онцгойлон авч үзэх асуудалгүй байна.

#### **3.12 Аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл**

Сонгуулийн ерөнхий хорооны даргын төсвийн 2017 оны жилийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн завсрын аудитаар 8,353.8 сая төгрөгийн бүртгэлийн алдааг залруулж, жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар материаллаг алдаа зөрчил илрээгүй байна. Бид үйлчлүүлэгчийн үйл ажиллагааг хэвийн үргэлжлүүлэхэд анхаарвал зохих асуудлаар менежментийн захидлаар 1 зөвлөмж хүргүүлэн ажиллаа.



### 3.13 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Сонгуулийн ерөнхий хорооны даргын төсвийн 2016 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар Сонгуулийн ерөнхий хорооны нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт үндсэн хөрөнгийн элэгдлийг тооцох хугацааг тусгах, нэмэлт өөрчлөлт оруулах, байгууллагын үйл ажиллагаанд тавих дотоод хяналтын тогтолцоог бүрдүүлэх, сонгуулийн зарим зардлыг холбогдох эрх зүйн актын дагуу зарцуулах зэрэг материаллаг бус алдаа, зөрчлүүдэд 3 зөвлөмж өгсөн бөгөөд байгууллагын удирдлагууд хяналт тавьж ажилласан байна. Зөвлөмжийг 100 хувь биелүүлж ажилласан байна.

Эдгээр зөвлөмжийн биелэлтийг Сонгуулийн ерөнхий хорооны 2017 оны 10 дугаар сарын 17-ны 174 дүгээр албан бичгээр ҮАГ-т ирүүлсэн болно.

Дэлгэрэнгүй мэдээллийг ажлын баримтад хавсаргасан болно.

### 3.14 Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитын материаллаг байдлын түвшинг Аудитын олон улсын стандарт 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд төлөвлөлтийн шатанд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2017 оны жилийн эцсийн нэгтгэсэн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зарлагыг сонгов.

Сонгуулийн ерөнхий хорооны даргын төсвийн 2017 оны нэгтгэсэн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын гүйцэтгэл 23,157.5 сая төгрөг бөгөөд түүний 1.0 хувь 231.6 сая төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажуулав.

Гүйцэтгэлийн шатанд материаллаг байдлын түвшинг өөрчлөн тогтоох шаардлагагүй гэж үзсэн болно.

### 3.15 Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Сонгуулийн ерөнхий хорооны даргын төсвийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг баталгаажуулах ажлыг Аудитын олон улсын стандартын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Сонгуулийн ерөнхий хорооны даргын төсвийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн болон илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдийг холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн байна гэж үзэж “Зөрчилгүй” санал дүгнэлт гаргалаа.

Аудитын явцад илэрсэн зөрчлийн талаарх үнэлэлт дүгнэлтийг энэ тайлангийн 3.9-т тусгасан бөгөөд залруулаагүй алдаа, зөрчлийг материаллаг байдлын түвшинтэй харьцуулахад аудитын санал дүгнэлтийг хязгаарлах үндэслэлгүй байна.

Аудитын санал дүгнэлтийг энэ тайлангийн 2 дугаар хэсэгт үзүүлэв.

### 3.16 Үр өгөөжийн тооцоолол

Сонгуулийн ерөнхий хорооны даргын төсвийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар үр өгөөж бүртгэгдээгүй болно.



#### **4 МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ**

Үндэсний аудитын газар аудит бүрийн төгсгөлд илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгчид зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүүгийн хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг билээ.

Энэхүү менежментийн захидлын агуулга Аудитын олон улсын стандарт, Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт болон аудитын горимоос урган гарсан болно. Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн талаар санал дүгнэлт гаргахад бидний горим зориулагдсан.

Энэ нь Сонгуулийн ерөнхий хорооны нягтлан бодох бүртгэлийн бодлого, түүний дагуух бүртгэлийг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг Та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан Сонгуулийн ерөнхий хорооны санхүүгийн ажилтнуудад талархал илэрхийлье.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн нэгтгэсэн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав.



**4.1 Санал тоолох машин, програм  
хангамжийн ашиглалтын талаар**

**Тэргүүлэх ач холбогдол №1**

**ҮАГ-ын ажиглалт:**

Үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй 12,951.3 сая төгрөгийн анхны өртөг бүхий сонгуулийн санал тоолох машин болон програм хангамжийн ашиглах хугацаа 2017 онд дуусч, элэгдлийн зардлаараа өртгөө бүрэн нөхөж дууссан байна. Гэвч уг хөрөнгийг дахин ашиглах, актлаж устгах, худалдах эсэх талаар өмч хамгаалах комиссын дүгнэлт гаргаагүй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйл “эзэмшилдээ байгаа илүүдэл буюу ашиглах хугацаа дууссан, шаардлага хангахгүй болсон эд хөрөнгийг худалдах, шилжүүлэх, устгах” хэсгийн 31.3.1-д “худалдах, шилжүүлэх, устгах эд хөрөнгийн талаар өмч хамгаалах Байнгын зөвлөл дүгнэлт гаргасан байх”, 31.3.2-т “илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нь нөхсөн, ... засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн үнийг төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай зөвшилцөн тогтоох” заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

**Эрсдэлүүд:**

Төсвийн тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль зөрчигдөх, Төсвийг үр ашиггүй, хэмнэлтгүй зарцуулах, шаардлагагүй худалдан авалт хийх;

**ҮАГ-ын зөвлөмж:**

- Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах” гэж заасныг баримтлан хөрөнгийн дахин үнэлгээ хийж ашиглах, актлаж устгах, худалдан борлуулах эсэхийг өмч хамгаалах комисс болон холбогдох байгууллагаар шийдвэрлүүлж ажиллах;

- Зөвлөмжийн биелэлтийг 2018 оны 9 дүгээр сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;

**Төсвийн захирагчийн хариу:**

Асуудлын бүртгэлийг үйлчлүүлэгчийн удирдлага, санхүүгийн ажилтанд танилцуулсан болно.

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА  
ЗӨРЧИЛГҮЙ  
САНАЛ ДҮГНЭЛТ



## 5 АУДИТ ХИЙГДСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 5.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мян.төг/

Тайлангийн үзүүлэлт	2016 оны 12-р сарын 31	2017 оны 12-р сарын 31
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	359,650.8	1,175,833.0
МӨНГӨН ХӨРӨНГӨ	0.0	0.0
БОГИНО ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ	0.0	0.0
АВЛАГА	0.0	0.0
УРЬДЧИЛГАА	0.0	0.0
БАРАА МАТЕРИАЛ	359,650.8	1,175,833.0
НӨӨЦИЙН БАРАА	0.0	0.0
БУСАД ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ	0.0	0.0
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	576,682.2	310,705.6
ҮНДСЭН ХӨРӨНГӨ	576,682.2	310,705.6
Биет хөрөнгө	315,791.6	256,314.5
Биет бус хөрөнгө	260,890.5	54,391.0
Бусад хөрөнгө /ТӨҮГ/	0.0	0.0
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	936,333.0	1,486,538.6
НИЙТ ӨР ТӨЛБӨР	0.0	0.0
БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	0.0	0.0
УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	0.0	0.0
ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	936,333.0	1,486,538.6
Засгийн газрын хувь оролцоо	936,333.0	1,486,538.6
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	14,410,826.1	14,410,826.1
Хуримтлагдсан үр дүн	-13,475,704.6	-12,925,499.0
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,211.5	1,211.5
ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	936,333.0	1,486,538.6



## 5.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мян.төг/

Тайлангийн үзүүлэлт	2016 оны 12-р сарын 31	2017 оны 12-р сарын 31
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	31,371,199.8	23,707,755.1
ТАТВАРЫН БУС ОРЛОГО	359,346.4	742,519.4
Нийтлэг татварын бус орлого	359,346.4	742,519.4
ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	31,011,853.4	22,965,235.7
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	33,047,373.7	23,157,549.5
УРСГАЛ ЗАРДАЛ	33,047,373.7	23,157,549.5
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	29,410,867.7	22,676,195.6
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	417,146.5	392,943.0
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	45,885.9	44,236.4
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	13,690.0	5,770.0
Хангамж, бараа материалын зардал	50,419.2	67,302.8
Томилолт, зочны зардал	2,556.7	3,285.5
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	175,453.4	194,584.6
Бараа үйлчилгээний бусад зардал	28,705,716.0	21,968,073.2
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	3,636,506.0	481,353.9
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	0.0	0.0
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	-1,676,173.9	550,205.6
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	0.0	0.0
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	0.0	0.0
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	-1,676,173.9	550,205.6



### 5.3 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мян.төг/

Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Цөөнхийн хувь оролцоо	Нийт цэвэр хөрөнгө/өмч
<b>2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	2,612,507.0	0.0	2,612,507.0
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.0	0.0	0.0
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2,612,507.0	0.0	2,612,507.0
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0.0	0.0	0.0
Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	0.0	0.0	0.0
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.0	0.0	0.0
Тайлант үеийн үр дүн	-1,676,173.9	0.0	-1,676,173.9
2016 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	936,333.0	0.0	936,333.0
2017 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	936,333.0	0.0	936,333.0
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.0	0.0	0.0
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	936,333.0	0.0	936,333.0
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0.0	0.0	0.0
Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	0.0	0.0	0.0
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.0	0.0	0.0
Тайлант үеийн үр дүн	550,205.6	0.0	550,205.6
<b>2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>1,486,538.6</b>	<b>0.0</b>	<b>1,486,538.6</b>

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

**ЗӨРЧИЛГҮЙ  
САНАЛ ДҮГНЭЛТ**

#### 5.4 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мян.төг/

Тайлангийн үзүүлэлт	2016 оны 12-р сарын 31	2017 оны 12-р сарын 31
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	31,011,853.9	22,969,526.6
ТАТВАРЫН БУС ОРЛОГО	0.5	4,291.0
Нийтлэг татварын бус орлого	0.5	4,291.0
ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	31,011,853.4	22,965,235.7
НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	31,011,853.9	22,969,526.6
УРСГАЛ ЗАРДАЛ	31,011,853.9	22,969,526.6
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	27,375,347.9	22,488,172.7
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	417,146.5	392,943.0
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	45,885.9	44,236.4
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	13,690.0	5,770.0
Хангамж, бараа материалын зардал	37,906.4	47,066.2
Томилолт, зочны зардал	2,556.7	3,985.5
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	175,453.4	194,584.6
Бараа үйлчилгээний бусад зардал	26,682,709.0	21,799,587.0
ХҮҮ	0.0	0.0
ТАТААС	0.0	0.0
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	3,636,506.0	481,353.9
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	0.0	0.0
НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	0.0	0.0
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.0	0.0
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.0	0.0



## 5.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мян.төг/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
I.НИЙТ ЗАРЛАГА БА ЗЭЭЛИЙН ДҮН	15,760,965.2	15,344,560.0	416,405.2	97.4
II.НИЙТ ЗАРЛАГЫН ДҮН	15,760,965.2	15,344,560.0	416,405.2	97.4
IV.УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	15,760,965.2	15,344,560.0	416,405.2	97.4
Бараа, үйлчилгээний зардал	15,719,710.7	15,306,973.5	412,737.2	97.4
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	440,290.4	392,943.0	47,347.4	89.2
Үндсэн цалин	322,009.6	286,913.5	35,096.1	89.1
Нэмэгдэл	93,124.9	82,465.3	10,659.6	88.6
Унаа хоолны хөнгөлөлт	25,155.9	23,564.3	1,591.6	93.7
АО-оос НД-д төлөх шимтгэл	48,431.9	44,236.4	4,195.5	91.3
Тэтгэврийн даатгал /7%/	30,820.3	28,150.5	2,669.8	91.3
Тэтгэмжийн даатгал /0.8%/	4,402.9	4,021.5	381.4	91.3
ҮОМШ өвчний даатгал /1%/	3,522.3	3,217.2	305.1	91.3
Ажилгүйдлийн даатгал /0.2%/	880.6	804.3	76.3	91.3
Байгууллага төлөх ЭМД /2%/	8,805.8	8,043.0	762.8	91.3
Байр ашиглалтын зардал	8,638.5	5,770.0	2,868.5	66.8
Байрны түрээс	8,638.5	5,770.0	2,868.5	66.8
Хангамж, бараа материалын зардал	49,313.3	47,066.2	2,247.1	95.4
Бичиг хэрэг	7,765.3	7,764.8	0.5	100.0
Тээвэр шатахуун	26,511.1	26,081.6	429.5	98.4
Шуудан холбоо	13,825.1	12,035.2	1,789.9	87.1
Бага үнэтэй түргэн элэгдэх зүйл хялдалдан авах	1,211.8	1,184.6	27.2	97.8
Томилолт зочны зардал	6,709.7	3,985.5	2,724.2	59.4
Дотоод томилолт	6,709.7	3,985.5	2,724.2	59.4
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр	195,416.1	194,584.6	831.5	99.6
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	191,653.2	191,492.9	160.3	99.9
Даатгалын үйлчилгээ	1,629.5	1,531.7	97.8	94.0
Тээврийн хэрэгслийн татвар	199.0	180.0	19.0	90.5
Тээврийн хэрэгслийн оношилгоо	66.0	66.0	0.0	100.0
Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,808.4	1,254.0	554.4	69.3
Банк санхүүгийн байгууллагын үйлчилгээ	60.0	60.0	0.0	100.0
Бараа, үйлчилгээний бусад зардал	14,970,910.8	14,618,387.7	352,523.1	97.6
Бараа үйлчилгээний бусад зардал	14,954,080.8	14,605,465.8	348,615.0	97.7
Хичээл үйлдвэрлэлийн дадлага	16,830.0	12,921.9	3,908.1	76.8
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	41,254.5	37,586.5	3,668.0	91.1
ЗГ-ын урсгал шилжүүлэг	26,124.5	26,076.5	48.0	99.8
ЗГ-ын гадаад шилжүүлэг	26,124.5	26,076.5	48.0	99.8
Бусад урсгал шилжүүлэг	15,130.0	11,510.0	3,620.0	76.1
АО-с олгох бусад тэтгэмж, урамшил	6,730.0	3,110.0	3,620.0	46.2
Нэг удаагийн тэтгэмж, шагнал, урамшуулал	8,400.0	8,400.0	0.0	100.0
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	15,760,965.2	15,344,560.0	416,405.2	97.4
Төсвөөс санхүүжих	15,760,965.2	15,344,560.0	416,405.2	97.4
Туслах үйл ажиллагааны орлогоос	0.0	0.0	0.0	0.0
Мөнгөн хөрөнгийн эхний үйлдэгдэл	0.0	0.0	0.0	0.0
Мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.0	0.0	0.0	0.0

